

УДК 930.85+398.8

ОРОСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТЭН Б.Я. ВЛАДИМИРЦОВЫН СУДАЛЖ ТЭМДЭГЛЭСЭН ОЙРАД АРДЫН ДУУНЫ ХОЖМЫН ҮНЭ ЦЭН

Өрнөхдэлгэр Д.

МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн Хэл зохиолын тэнхимийн эрхлэгч
Хэл бичгийн ухааны доктор, профессор.

Хаяг: urnukhdelger.d@gmail.com

Хураангуй

Орчин үеийн Дэлхийн Монгол судлалд Оросын Монгол судлалын түүх чухал байр суурь эзэлдэг билээ. Оросын Монгол судлалын түүх нь алдартай эрдэмтдийн нэртэй холбоотой (Н.Я. Бичурин, О.М. Ковалевский, Д. Банзаров, В.П. Васильев, А.М. Позднеев, А.Д. Руднев, Б.Я. Владимирцов). Академич Б.Я. Владимирцов шинжлэх ухааны бүтээлч чанараараа энэ салбарт томоохон хувь нэмэр оруулсан юм. Хэвлэгдсэн бүтээлүүд нь Оросын нэрт эрдэмтний шинжлэх ухааны ашиг сонирхлын өргөн хүрээний гэрч юм. Судлаач 1908 оноос эхлэн баруун монголоор аялж монгол ардын аман зохиол, түүний дотор ойрад дууны зүйлсийг цуглуулж эхэлсэн бол дараа нь 1911, 1926, 1935 онуудад монгол нутгаар дахин аялж, аман зохиол, түүх, нутгийн аялгуу, хэл шинжлэл, бичиг соёлын дурсгалын гээд олон чиглэлээр судалгаа шинжилгээний ажлаа өргөтгөсөн байна. Түүний “Образцы народной словесности” бүтээл (1926) ойрадын дуу судлалд чухал ач холбогдолтой бүтээл бөгөөд “Баатар бээлийн унага”, “Нарийн говийн зээрд”, “Харгай дүнгийн алим”, “Зээр-гэнэтийн шил” зэрэг ойрад нутгийн дууг аман аялгууны онцлогийг хадгалан галиг үсгээр хэвлүүлжээ. Энэхүү илтгэлд энэхүү ардын дуунуудыг галиг үсгээр тэмдэглэсэн онцлогийг авч үзжээ.

Түлхүүр үгс

Б.Я.Владимирцов, Оросын Монгол судлал, ойрад ардын дуу, нутгийн аялгууны үг хэллэг.

UDC 930.85+398.8

THE LATER VALUE OF OIRAD FOLK SONGS MARKED BY THE RESEARCH OF RUSSIAN MONGOLIST SCIENTIST B.Y. VLADIMIRTSOV

Urnokhdelger D.

Head of the Language and Literature Department of the Khovd province branch of the Mongolian State University

Doctor of Linguistics, Professor.

E-mail: urnukhdelger.d@gmail.com

Annotation

The history of Russian Mongolian studies occupies an important place in modern World Mongolian studies. The history of Russian Mongolian studies is associated with the names of famous scientists (N. Ya. Bichurin, O. M. Kovalevsky, D. Banzarov, V. P. Vasiliev, A. M. Pozdneev, A. D. Rudnev, B. Ya. Vladimirtsov). Academician B. Ya. Vladimirtsov made a great contribution to this field with his scientific creativity. Published works testify to the wide range of scientific interests of the famous Russian scientist. In 1908, the researcher traveled to Western Mongolia and began to collect Mongolian folklore, including Oirat songs. Then, in 1911, 1926, and 1935, he traveled to Mongolia again, and collected field materials on oral literature, history, culture, local dialects, and written monuments. His book "Obraztsy narodnoy slovesnosti" (1926) is an important work in the study of Oirat songs, and it contains Oirat local songs such as "Batar Beeliyin Unaga", "Nariyin Goviyin Zeerd", "Khargai dungiyin Alim", and "Zeergenetiyyin Shil" in transliteration, preserving the features of the oral dialect. The article discusses the features of these folk songs, denoted in italics.

Key words

B. Ya. Vladimirtsov, Russian Mongolian Studies, Oirat folk songs, vocabulary of local dialects.

О Р Ш И Л

Монгол орноор зорчсон жуулчид, гадаадын судлаачид, сонирхогчид монголчуудын аж төрөх ёс, зан үйлийн онцлогийг ажиглан сонирхож, улмаар монголчуудын үг хэллэгээр илэрч байдаг ардын аман бүтээлүүдийн төрөл зүйлүүдээс олдох хэмжээгээр нь цуглуулж, судлаачдад мэдээлсэн, бас судлаачид нь судалсан, олзуурхан бүртгэлжүүлэн албажуулсан байдлаар шинжлэх ухааны байгууллагуудын харьяа сан хөмрөгт хадгалагдан судалгаа шинжилгээний мэдээлэл, хэрэглэгдэхүүн болсоор байгаа билээ. Энэ бүх хэрэглэгдэхүүн нь шинжлэх ухааны байгууллагуудын мэдэлд байгаа тул мэргэжлийн судлаачдын анхаарлыг цаг ямагт татсаар байдаг. Эдгээрийн дотор ялангуяа ойрад аялгууг тэмдэглэсэн хэрэглэгдэхүүн нь өнөө үед их үнэ цэнтэй болно. Учир юу буй хэмээвээс тухайн үеийн хэлж дуудаж байгааг нэлээд тусган тэмдэглэсэн бичвэр нь тухайн аялгууны тухайлбал хэл ярианы онцлогийг хадгалж байгаа гэдгийг мартаж болохгүй. Эрт орой хэзээ нэгэн цагт сонирхон шимтсэн хэн хүн сонирхон судлах нь дамжиггүй.

Б. Я. Владимирцов Монгол оронд урт, богино хугацаагаар нийтдээ 5 удаа буюу анх оюутан байхдаа 1908 онд улмаар 1911, 1913–1915, 1925, 1926 онуудад ирж ажилласан байна. Тэрбээр “би оюун бодлоороо Монгол оронд байнга очиж байна. Намайг тийш нь маш их татах юм”, “тэнд дахин очих аз завшааныг хувь заяа олгоно хэмээн би найдаж байна”, “Монгол орон, Ховдын тойрог миний хоёр дахь эх орон юм”, “Би тэдний дунд байсан шиг тийм сайхан хүлээн авалт дайллагатай хаана ч таараагүй шиг санагдана” хэмээн өгүүлсэн байдаг. Б.Я. Владимирцов 1926 онд Монгол Улсад эрдэм шинжилгээний томилолтоор ирсний үр дүнд монголчуудын хэл шинжлэл, угсаатны зүйн талаарх эрдэм шинжилгээний үнэт бүтээл болох “Халхын Цогт тайжийн хадны дээрх бичээсүүд” өгүүллийг хэвлүүлжээ. 1929 онд тэрбээр монгол хэл шинжлэлийн түүхэн дэх “Монгол хэл ба халх аялгууны харьцуулсан дүрэм” хэмээх томоохон чухал судалгааны ажлын эхний хэсгийг хэвлүүлэв.

Б.Я. Владимирцов бол монгол хэл шинжлэл, монгол аман зохиол судлал, Монголын түүхийн судалгаа хийгээд угсаатны зүйн талаар эн тэнцүү үнэлэгдэхүйц бүтээл туурвисан учраас Монгол судлалын эдгээр салбарын эрдэмтэд бүгд өөр өөрийн судалгааны тэргүүлэх эрдэмтэн гэдгийг хүлээн зөвшөөрч, өөрсдийн салбартаа түлхүү хамаатуулахыг оролддог билээ.

Б.Я. Владимирцовын эрдэм шинжилгээний ажилд шамдаж эхэлсэн XX зууны эхээр энэ үед Хельсинкийн Их сургуулийн профессор Г. И. Рамстедт улмаар А. Д. Руднев, В. Л. Котвич нарын эрдэм шинжилгээний бүтээлүүдтэй холбоотойгоор монгол судлалд түүхэн харьцуулсан судалгааны шинэ чиглэл бий болоод байсан юм. Ялангуяа А.Д. Рудневийг багшилж эхэлсэн 1903 оны үед Г. И. Рамстедт ч мөн эрдэм шинжилгээний ажлаа эхэлж байв. Тэр ч атугай удалгүй энэ хоёр эрдэмтэн дотно нөхөрлөж А.Д. Руднев нь Г.И. Рамстедтын шинжлэх ухааны үзэл санааг Орос оронд сурталчилан таниулагч болж, түүний хүчин чармайлтаар Г. И. Рамстедтийн бүтээлүүд хэвлэгдсэн даруйдаа орос хэлээр орчуулагдан, Петербургийн монголч эрдэмтэд түүний үзэл бодлоор замнах болжээ. Чухам ийм нөхцөлд Б. Я. Владимирцовын алтай овгийн хэлнүүдийн талаарх үзэл бодол төлөвшин тогтсон байна.

Монголч эрдэмтэн Б. Я. Владимирцовын бүтээл, манай эх орны соёл, шинжлэх ухааны хөгжилтөд үлэмж хувь нэмэр болохоор барахгүй, дэлхий дахины монголын судлалд үнэлж баршгүй ховор өв болон үлдэж, түүгээр монголыг судлагчдын бүхэл үе хүмүүжсээр байна. Академич Владимирцов эрдэм шинжилгээний 70 шахам зохиол хэвлүүлсэн бөгөөд түүний нэлээд хэсэг нь өрнө, дорнын хэлээр орчуулагджээ.

Монголын түүх, хэл, тулгуур бичиг, аман зохиолыг цуглуулан тэмдэглэх, судлах талаар үлэмж хувь нэмэр оруулсан хүний нэг нь бол алдарт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов юм. Тэрбээр «Монголын нийгмийн байгуулал» (1934), «Монгол бичгийн хэлийг халхын аялгуутай харьцуулсан хэлзүй. Удиртгал болон авиазүй» (1929), «Панчатантраас авсан монгол үлгэрийн цоморлиг» (1918), «Монгол ойрадын баатарлаг тууль» (1923) гэх мэт номуудыг хэвлүүлсэн билээ. Мөн 1923 онд Б. Я. Владимирцов тод үсгээс орос хэлэнд орчуулан 24 цуврал үлгэр бүхий «Шидэт хүүрийн үлгэр»-ийг Москва хотод хэвлүүлсэн бөгөөд 1958 онд дахин хэвлэжээ (1923).

Б. Я. Владимирцов XX зууны эхээр Монгол улсын баруун нутгийн ойрад хүмүүсийн дотор эрдэм шинжилгээ хийж хэдэн жил суухдаа баяд, дөрвөд, урианхай, мянгад зэрэг овог аймгуудаас нэлээд олон аман зохиолын эх хэрэглэгдэхүүн цуглуулсан бөгөөд тэрхүү эх хэрэглэгдэхүүндээ тулгуурлаж «Монгол ардын аман зохиолын жишээ» (Баруун хойд Монгол) гэсэн номоо 1926 онд Ленинград хотод орос маягийн эрдэм шинжилгээний галиг үсгээр хэвлүүлсэн юм (1926). Тус эх хэрэглэгдэхүүн дотор 22 аман үлгэр, нэг бүлэг «Жангар», 17 ерөөл, дөрвөн баатарлаг тууль болон 118 дуу орсон байв. Тус ном нь 1970 онд Англид гэрэл зургаар буулгагдаж дахин хэвлэгджээ. 2005 онд Оросын ШУА-ын «Дорнын утга зохиол» хэвлэлийн газраас «Монгол хэл шинжилгээний бүтээлүүд» гэсэн нэртэйгээр Москва хотод бас дахин хэвлэсэн байна (2005).

Б. Я. Владимирцов (1926) монгол дууны яруу найргийг баруун монголын баяд, дөрвөд, захчин, торгууд, урианхай аялгууг судлахад материал болгон 118 дууг орос галигаар тэмдэглэн хэвлүүлэхийн хамт монгол дууг “айдам дуун”, “шаштра дуун”, “шалиг дуун” гэж ардын нэр томъёогоор гурван төрөл болгон үзсэн нь дууны төрөл зүйлийг судлахад нэлээд тодорхой чиглэл болно. 1928 онд академич Б. Я. Владимирцов халимаг хэлний зөв бичгийн дүрмийг сайжруулахад зориулагдсан хуралд оролцов (Омакаева, 2014).

1. Ойрад аялгуу, үгийн сангийн онцлогийг тэмдэглэсэн нь:

Ойрад аман аялгууны “г, х” авиа эр эгшигтэй үгэнд “г, к” авиа эм эгшигтэй үгэнд зохицон хэлэгдэнэ. Эм үгийн “х” гол төлөв хамжсан “к”-аар хэлэгдэж байна. Жишээ нь:

Эрвгэр хонгр зээрдэ минь

Кэнаакин (хэнийх нь) сүрүктө(сүрэгт) байдак бол,

Кэнзэ (хэнз) бага дүү минь

Кэнаакин дэргэдэ суудук бол... [№ 1. Алтан богдын шилд, 1-р тал]

...Көк (хөх) булгийн амнда кийтнаа (хүйтний) будн татнаа

Килинцэ(хилэнц) нүгүл хоёрыгы аргалакчи бакии ламаан сургаал [№2. Хөх булгийн аманд, 2-р тал]

Орчин цагийн монгол хэлний үгийн хамжих “г” авиаг шүргэх “х” авиагаар хэлнэ. Жишээ нь:

Баруун Сүмбрийн уулнда

Батхн (батгана) унаартажи үзүкднаа [№ 28. Баруун Сүмбэрийн ууланд, 14-р тал]

Өнчин цагаан ботхнаас (ботгоноос) [№ 51. Сандуултай модонд, 28-р тал]

Харлак манн көөргн ай-ху

Хабтхн (хавтага) дундаан өргнаа ай-ху [№ 50. Саадаг сажлим салхинд, 27-р тал]

Ойрад аман аялгуунд үгийн эхний эгшиг “о”-ших үзэгдэл байдаг. Жишээ нь:

Хара шовуун (шувуун) дэkdээхаа

Яачил харгаан чолуун(чулуу),

Яасан хатуу чолуун [№ 5. Шар шувууны дэгдээхий, 2-3-р тал]

Ойрад аман аялгууны “н”-ийг маш тодорхой хэлдэг бөгөөд ихэнх нэр үгэнд “н” дагавар хаягдаагүй хэвээр байна. Жишээ нь:

Захын ганца модн (мод)

Занаажн, сэксээжн хоцрв-л

Ганца моднаа сабдагни

Ганцаарн ёвууксн бурхдын сакуусн (сахиус)

Өврийн харгаан мокн (бохь) жалжихада (зажлахад),

Данчиги амттаа

Монгол бичгийн хэлний “ө” эгшиг нь ойрад аялгууны зарим үгэнд “о” эгшгээр дуудагдана. Жишээ нь:

Көк зүлүк найхлаат байнаа-л,

Коккок (көкүгэ) шувуун донгдн жиргнаа.

Монгол бичгийн хэлний эр үгийн “у” эгшгийг ойрад аялгууны зарим үгэнд “ө”-ээр сэлгэж хэлнэ. Жишээ нь:

Өмаар (урду) халаахн,

Өвр Хангаа,

Ардаан халаахн,

Алтаа, Хангаа.

Орчин цагийн монгол хэлний “ө” эгшгийг ойрад аялгууны зарим үгэнд “ү”-ээр сэлгэж хэлнэ. Жишээ нь:

Тобчи шилвийн хадмза, бөмбүүлаа!

Ираат, ираат үмсээраа (өмсөөрэй), бөмбүүлаа

Ойрад аман аялгуунууд дотроо зарим үгэнд “о~ө” эгшгийг сэлгэж хэлнэ.

Жишээ нь:

Кооркм (хөөрхөн) бораан уны-да бөмбөгр,

Кооркн (хөөрхөн) куудаан очн-да бөмбөгр

Көөркни шарга морин

Көндөөнаан гобаар туулнаа,

Көөркнлаа дуртаа богдыгаан

Алтын шираан дээр залнаа.

Мөн “кооркн, кооркм” гэхэд “н, м” хоёр эгшиг сэлгэж болохыг харуулж байна.

Авиа гээгдэх үзэгдэл нэлээд ажиглагдаж байна. Жишээ нь:

Хар морн харнглжаагаа болво, бөмбүүлаа!

Харнхуу сөөгаар (шөнөөр) мордаараа, бөмбүүлаа!

Кээр морн кэбтраасн холхн, бөмбүүлаа!

Харүүн сөөгаар ирээраа, бөмбүүлаа!

*Гандн-булгийн цэцэк
Гантхаан байсн цэцэк,
Газрын холын чамта
Танилжи (танилцаж) суухын дэмбрил.*

Үгийн эцсийн “н” гийгүүлэгчийн хэлний урдуур хэлэх чанарыг хэвээр хадгалсаар байна. Гэтэл энэ нь бусад монгол хэлнүүдэд хэлний хойгуурх “нг” болжээ. Гэвч ойрад хэлний нутгийн аялгуунууд нь авианы зүйн бусад талаар бусад монгол хэлнүүдийн өнгөрүүлээгүй тийм ноцтой өөрчлөлтүүдийг үзсэн байна. Хос эгшгүүд нь тус тус зохих урт эгшгүүд болсон байна. Жишээ нь:

*Хурцу чиктаа (чихтэй) хар минь
Хурдаан дөлүрмаан хурдтаа (хурдтай),
Хувилгта ламын шэвн
Хумснаасн түрүүн дөлүрмаан зоригтаа (зоригтой).
Шаазгаан (шаазгайн) бичхн дэждээхаа (дэгдээхэй)
Шаханжи буугаат нисн дээ,
Шалик зантаа чамтаагаан (чамтайгаа)
Шалгилжи суухуунчи яахуубда?*

Нэгдүгээрээс бусад үеийн оо, өө, ээ урт эгшгүүд урт аа, ээ болсон байна. Жишээ нь:

*Көөркни шарга морин
Көндөөнаан (хөндийнхөө) гобаар(говитор) туулнаа,
Көөркнлаа дүртаа богдыгаан (богдыгоо)
Алтын шираан (ширээ) дээр залнаа.
Алтын(Алтайн) уулын шилндэ(шилд)
Алтн горгуулдаа жиргнаа (жиргэнэ ээ),
Амрак ики(их) ноёдн
Данишк мандлаан өргөнаа (өргөнө өө).*

Нэгдүгээрээс бусад үеийн богино эгшгүүд нь туйлын балархай болсон байна. Энэ учраас нэлээд шинжлэгчид ойрдын аялгуунуудад эдгээр эгшгүүд огт байхгүй болж нэгдүгээрээс бусад үед зарим яруу гийгүүлэгч үе бүтээх үүргийг гүйцэтгэдэг болжээ. Жишээ нь:

*Захын ганца модн (модон)
Занаажиги, сэксээжиги хоцрв-л,
Занакчын ганца күүкн (күүкэн)
Занаажиги, сэксээжиги хоцрв-л,*

гэх мэтчилэн “салкан биш салкн, күүкэн биш күүкн, жсөөлкөн биш жсөөлкн, амар мэнд биш амр мэнд, кооркон биш кооркн” гэх мэт үгс нэлээдгүй тохиолдож байна.

Ойрадын аялгуунуудад угаасаа “и” эгшигтэй байсан эр эгшигт олон үгс энэхүү эгшгийн тагнайшуулах нөлөөгөөр эм эгшигт үгэнд шилжээд дараа нь мөнхүү “и” эгшиг нь өөрөө бас ижилссэн нь онц сонирхолтой юм. Жишээ нь: Морин-мөрин-мөрөн-мөрн, бирагу-бирүү- бүрүү, сибагу- шовуу – шувуу г.м.

Авиа сэлгэлт буюу нэг үг олон янзаар бичигдэж болдог нь нутгийн аялгууны нэгэн онцлог. Жишээ нь:

*Морь – мор, морн, мөр, мөрн,
Хөөрхөн – Кооркн, көөркн
Үгүй – угаа, угаа, гоо, угоо*

*Байтал – байтл, вайтл**Буурал – буурл, вуурл**Цасан – цасн, цасм**Явна – ёвна, ёмнаа**Чухал – чухл, чухук*

Владимирцовын цуглуулсан дуунуудын бас нэгэн онцлог бол нутгийн аялгуу болон тухайн дуучдын дуулах хэллэгийн онцлог буюу дуулахдаа хөг ая нэмэх зориулалтаар зарим үгсийнх нь арын эгшиг балархайших үзэгдэл нэлээдгүй ажиглагдаж байна. Эдгээр үгсийн ихэнх үгс нь эртний монгол бичгийн хэлний “-да⁴” нөхцөлтэй байгаа нь эртний хэлээ хадгалан үлдэж буй нэгэн онцлог гэж хэлж болохоор. Жишээ нь: *богдо, тэбкэ, мэндэ, эндэ, тэндэ, үүдндө, амнда, салкнда, шилиндэ, уулндө, дугундо, аянда, буцундо, ганца, мөнкө, наадамда, далду,сүлдө, Алтаада, хойто, дунду, талда* гэх мэт олон үгс ажиглагдаж байна.

Сонгодог монгол бичгийн хэлний онцлогийг хадгалж үлдсэн үгс цөөнгүй байна. Жишээ нь: “Ганц – гагца, Амьсгал – амисхал, Урсгал – урсхал, Тавина – талвина, Асгарнаа – асхарнаа, Өрүүн – өрлаа – өглаа – **өглөө**, Эвраан – ээрээ – **өөрийн**, Кооркм – кооркн – көөркн – **хөөрхөн**” гэх дамжлагаар төв аялгуунд орсон буюу төв аялгуундаа уламжлагдсан үзэгдэл бүхий үгс цөөнгүй анзаарагдаж байна.

Ойрад аялгуунд нэг үг авианы олон янзын хувиралтай хэлэгдэх тохиолдол багагүй байна. Тухайлбал, “үгүй” хэмээх үг нь үгаа-угоо-гоо-угаа гэх мэт олон янзаар дуудагдаж байна. Энэ нь ойрад аялгуунд авианы хувьсал нэгээс нөгөөд бүрэн шилжиж дуусаагүйг харуулж байна. Нөгөө талаар халх ба бусад аялгууны нөлөө байна. Мөн нутгийн аман аялгууны үгийн санг тээж хадгалж ирснээрээ дахин давтагдашгүй үнэ цэнтэй билээ

*Тэвхэг тэвхэг толгойд нь**Тэсгэнэ шарилж ганхана* (Алтан богдын шил)*Намрын хонгор салхинд**Намайг чамайг салгагч**Магнай хээн охмор!* (Намрын хонгор салхи)*Эрэвгэр хээрээ уналаа бөмбүүлээ**Эртний ерөөлөөр харгалаа бөмбүүлээ* (Зандан мод)*Алаг хуартай шаазандаа**Цэгээ хийгээд өгнө* (Алаг хуартай шаазан)*Тоорой бандийг явахад**Тостой даавуу олдохыг уурлаа* (Тоорой банди)*Ганц санаатай Томбий чинь**Тоогүй цэргийн лимпаан даа* (Тоорой банди)*Саран төөлтэй хар минь**Самсаа дарам хурдтай**Сайшиг ноёны алдар**Ингэтлээ юундаа дэлгэрсэн* (Төмөр цагаан эхэнд)*Өвөр харгайн бэчир нь**Үзүүрээ дагаад ургадаг* (Сээрийн харгай мод)*Буурал мор нь хөлстэй л**Булгадар намайг завхай гэнэ*

Хар морь нь хөлстэй л
 Хасгууд намайг завхай гэнэ (Харгай дүнгээн алим)
 Арилдаг дагины дүү нар нь
 Хангинан дурсаж сууна (Харгай дүнгээн алим)
 Найман сарын шинэд
 Намч цэцэг дэлгэрнэ (Жавзандамбын гэгээн)
 Даршгүй дайг
 Шуну гагцаар дардаг (Нарийн говийн зээрд) гэх мэт.

Аман хэл ярианы өгүүлэхүйн онцлогийг сайтар тусгасны баримт нь энэ буюу. Ер нь эрдэм шинжилгээний галигийн нэгэн зүйл зорилго нь ярианы хэлээ дөхүү байдлаар тэмдэглэхэд оршиж байдаг.

2. Ардын дууны шүлгийн бүтэц, дүр дүрслэл:

Монгол ардын дууны шүлэгт үг давтах журам хоёр янз (Арван..., 1984). Нэгдүгээрт, шүлгийн эхний сольбож холбосон шадын түрүүчийн үгийг нэг үгээр давтах, хоёрдугаарт, шүлгийн эцсийн үгсийг эн зэрэгцүүлэн нэг үгийг давтан бадгийн төгсгөлийг бүхэлд нь холбодог байна (Хорлоо, 1981: 38). Ардын дуунд давталт нь яруу найргийн бусад төрөл зүйлээс нэн илүү хэрэглэгддэг. Давталтын мөр өгүүлбэр нь тухайн бадгийн агууллагад тулгуурлагддаг учир бадаг бүр цаашид бүхэл нэг дууны агуулга утгыг дуурайлган товойлгож, санаа сэтгэлгээг гүнзгийрүүлэн хөг ая айзам хэсгийг улам тодруулж нөлөөлөх хүчинг нэмэгдүүлдэг. Жишээ № 1:

*Зандн модн залгаа угаа бөмбүлэ,
 Залуу манда ялгаа гоо бөмбүлэ,
 Үзмийн ишиндэ үеин гоо бөмбүлэ,
 Үеаан манда ялгаа гоо бөмбүлэ,
 Самрын ишиндэ салаа гоо бөмбүлэ,
 Хар кээрийн унлаа бөмбүлэ,
 Харнху сөөваар(шөнө) эргилаа бөмбүлэ,
 Эрвгр кээрийн унлаа бөмбүлэ,
 Эртийн ерөөлаар харглаа(уулзах) бөмбүлэ,
 Эрвгр кээрийн нургнду(нуруунд),
 Эмээл байвл зандн,*

Экнртаа экнр гоо хоёрыгы

Энгийн күмүүнаас дуулн да... [№ 7. Зандан модон, 3-р тал]

Энэхүү дууны бөмбүлэ “бомбула” гэх давталт нь дууг чихэнд сонсголонт, санаанд аятай цээжлэхэд дөхөм болгож байгаа ба давталт болгондоо агуулгыг тодруулж санааг нь гүнзгийрүүлж өгч байна.

Жишээ № 2:

Даагн даагн харыгы

Дангаар унжи болдугой (болдоггүй),

Дамаан(дамын) амрак чамаагы

Дагуулаат морджи болдок би (болдоггүй) [№ 10. Дааган дааган хар, 4-р тал]

Энэ шүлэгт “дааган” гэдэг үгийг давтаж түүнийг дандаа унаж болохгүй гэсэн санаагаа, амраг сэтгэлтэй хүнээ дагуулаад явж болдоггүйтэй холбохын тулд давталтыг ашиглажээ. Өөрөөр хэлбэл энэ дуунд сэтгэлийн амрагтайгаа ханилан суух эрх чөлөөгүй цөхөрсөн сэтгэлээ гуниглан илэрхийлсэн өнгө аяс илэрч байна.

Жишээ № 3:

Шараа-лаа хаднаан уяанда (үеэнд)
Шарааны линхаан (лянхуа) цэцэк дэлгрнаа,
Шараа-лаа уургаан шимүүлүксн
 Ээжийнаан начийги яаяын-даа-коо.
Цагаан-лаа хаднаан уяандаа
Цагааны линхаан цэцэк дэлгрнаа,
Цагаан-лаа уургаан шимүүлүксн
 Ээжийнаан начийги яаяын-даа-коо.
Улаан-лаа хаднаан уяандаа
Улааны линхаан цэцэк дэлгрнаа,
Улаан-лаа уургаан шимүүлүксн

Ээжийнаан начийги яаяын-даа-коо [№ 9. Бөмбөгөр бөмбөгөр модонд, 4-р тал] гэсэн шүлгийн «АААБ» гэсэн толгой холболт буюу 1, 2, 3-р шадын эхэнд «шар, цагаан, улаан» гэсэн үгсээр толгой холбон давтсан нь уг дууны утгыг улам тод яруу болгосон байна. Мөн бадаг бүрийн төгсгөлийн «Ээжийнаан начийги яаяын-даа-коо» гэх бүхэл бүтэн шадыг оруулж өгсөн нь дууг илүү амьдлаг, уярам болгоод зогсохгүй байгалийн үзэгдлийг “лянхуа цэцэг”-ээр, хүний хүний ачлал элбэрлийн сэтгэлийг “ээж”-ээр төлөөлүүлэн зэрэгцүүлэхдээ “уураг”-аар тодотгож өгсөн байна.

Жишээ № 4:

Гандн-булгийн цэцэк
Гантхаан байсн **цэцэк**,
Газрын холын чамта
Танилжи (танилцаж) суухын **дэмбрил**
Улаан-булгийн цэцэк
Ургхаан байсн **цэцэк**,
Учиртаа жаалхн чамта

Ханилжи суухын **дэмбрил** [№ 24. Гандан булгийн цэцэг, 10–11-р тал]

Дээрх дууны 1-2-р шадын төгсгөлд “цэцэк” гэдэг үгийг давтсан нь “**гантхаан байсн**, улаан булгийн, ургхаан байсн” гэсэн үгсийг илүү тодруулж, хүч нэмж байгаагийн зэрэгцээгээр хайртай хүнээ хүсэмжлэн уулзаж учрахыг мөрөөдөн “дэмбрил” гэх үгээр бадаг бүрийг төгсгөж өгсөн нь дууг илүү уянгалаг болгож байна. Мөн “цэцэк” гэх үгийг сонгосон нь эмэгтэй хүнийг цэцэгтэй зүйрлэсэн нь аман ба бичгийн сонгодог уран зохиолын уламжлалыг дагажээ.

Шара шувуун дэkdээхаа (дэгдээхэй)

Шалваагаан төөраат нолмуурнаа,
Шалик зантаа чамтаагаан
Ингээжи юундаан даслаа?
Цохр шовуун дэkdээхаа
Көшөөтийн модндо донгднаа,
Көөркө жаалхн чамаасн
Ингээжи юундаан холдлаа?
Күрм (хүрэн) болжуу (болжмор) шувууны
Күраанаан (хүрээ) дээгүүр жиргинаа,
Күмүрлик (хүнлэг) жаалхн чамтаагаан

Ингэжи юундаан даслаа?

Шаазгаан бичхн дэkdээхаа

Шаханжи буугаат нисн дээ,

Шалик зантаа чамтаагаан

Шалгилжи суухуунчи яахуубда?

Хара шовуун дэkdээхаа

Харгнаан төөраат дэkdүүлнаа,

Хайлгн зантаа чамтаагаан

Харүүн эргижн золгнаа?

Тогруун жаалхн дэkdээхаа

Тоглжи буугаат нисн дэ,

Төгр жаалхн чамаасн

Төөритлаан юундо холдлаа?

Галуунаа жаалхн дэkdээхаа

Гангилжи буугаат ниснаа,

Газрын холын күм бухаа

Гансуурчи буугаат мордн даа.

Боширгон (богиширго) жаалхн дэkdээхаа

Бужигнжи жижижнаат нисн дээ,

Будуугийн бичхн чамаасн

Буцтлаан юундо холдлаа?

Өврийн моднаа шувуу нь

Өрүүнаан (өглөөний) сэрүүгаар жиргн дэ,

Өврийн хайртаа чамаасн

Өрлаан (үүрийн) сэрүүгаар хагацлаа.

Арын моднаа шувууны

Аснаа (үдэш) сэрүүгаар жиргин дэ,

Амрак бичхн чамаасн

Арг-угоо (аргагүй) күчүүндө (хүчинд) саннаа [№ 5. Шар шувууны дэгдээхий, 2-3-р тал]

Энэхүү дуунд арван төрлийн шувууг дурдаж өгсөн буюу шувууны үр төл болох дэгдээхэйгээр нь амраг хосын хайр сэтгэлийг төлөөлүүлж өгсөн нь сонирхол татаж байна. Дууны агуулгын хувьд амраг хосын уулзаж учрах, хагацаж холдох, санан дурсах бүхий үйлдлийг шувуудаар буюу шувууны үр төл болох дэгдээхэйгээр нь төлөөлүүлж өгсөн ба аливаа зүйлийн үр төл гэдэг энхрий зөөлөн, цэвэр ариун, эмзэг байдаг бол түүгээр амраг хосын хайр сэтгэлийн эмзэг нандин, ариухныг төлөөлүүлж өгсөн нь гайхалтай юм. Мөн ийм олон төрлийн шувуу тэрхүү нутаг нугад амьдардаг гэсэн санааг давхар дамаа гаргаж илэрхийлсэн онцлогтой байна.

3. Ардын дуунд ертөнцийг танин мэдсэн ухаарал туссан нь:

Ойрад ардын дууны зонхилох сэдвийн нэг бол сургаалын дуу юм. Энэ нь ардын уламжлалт ёс горим, төлөв даруу ажилсаг, хөдөлмөрийг дээдэлдэг, өвөг дээдэс эцэг эхээ хүндэлдэг, үнэнч шударга ёсыг эрхэмлэхийг сургамжилсан дуунууд болно. Сургаал дуу бол монголын эртний уртын дууны уламжлалт хэлбэр бөгөөд хүмүүсийн дотоод сэтгэлгээг сургаалын чанартай өөрмөц агуулга бүхий уянга дууны дүрслэлээр илэрхийлж байгаа зүйл юм.

Сургаал номлолын өнгө аястай дуу нь тухайн ард түмний ертөнцийг үзэх үзэл, мэдлэг ухааны нэгэн өвөрмөц илрэл бөгөөд энэ нь тэдний амьдралын арвин баялаг туршлагаас үүдэлтэй.

Үзүүр харгаан бичирн(мөчир)
Үзүүраан дагаат ургудук,
Үнүртаа күүкн ханлвааса(ханилваас),
Чээжин үлүмжи болдок.
Ар зураагийн модн
Салкаар матайдак гилаа-л,
Сайшик күмнаасн
Ховын үгаар хагацадак

«Сайн хүнээсээ ховын худал үгнээс болж хагацдаг» гэсэн шиг утгатай энэхүү хоёр мөр нь “ховын үг ёртой, хутганы үзүүр шортой” гэх ойрад ардын цэцэн үгтэй дүйцэх ба ховын үг хөөцөлдөх нь муу үйлийг дагуулж, сайн хүнээс нь хагацуулдаг учир хов живээс хол явахыг сургамжилсан санааг «сайшик күм»-ээр тодотгон гаргасан байна.

Үзүүр харгаан чимэгний
Савшин дүнгээжи харакднаа,
Үнүн үгийг кэлдэк
Эвраа ээжи минь санакднаа.
Төмрийн сайн зэврдугаа (зэвэрдэггүй),
Төрлийн сайн мартакддугаа (мартагддаггүй),
Зэсийн сайн зэврдугаа,
Зээнрийн сайн мартакддугаа...

Энэ нь хүний сайн нь мартагддаггүй гэсэн санааг илтгэсэн ба үр хүүхдээ хүний сайн нь байгаасай гэдгийг ойлгуулахын тулд дуундаа энэхүү цэцэн үгийг оруулж өгсөн байна. Мөн “Үнэн үгийг хэлдэг өөрийн ээж минь санагдана” хэмээх нь энгийн нэгэн утгатай харагдаж буй боловч цаад утга агуулга нь хүний хамгийн сайн найз бол ээж, аав нь бөгөөд тэд л чамд хэзээд үнэнч, үнэнийг өгүүлэгч байдгийн учир ээж ааваа хүндэтгэн хайрлаж, үг сургаалыг нь өлгөж авах хэрэгтэйг сургамжилжээ.

Ургумл улаан нарыги
Улаан үүлн халхлнаа,
Урн цэцэ ухааги
Уурын мунхуг эзлнаа
Нарин шара цэцэг нь
Намрын сарда хөврнаа,
Найднгоо мунхуг хоёрыги
Уурын мунхуг эзлнаа.
Наймн түмн ишваан иши
Наймн түмаарн цуглуулукчи

Ээжин аавн хоёр минь [№ 15. Төмөр лаа цагийн эхэнд, 7-р тал]

хэмээн нар үл гэрэлтэхийн шалтгаан нь үүлэнд, ухаан эвдэгдэхийн шалтгаан нь уурын мунхагт оршино. Байгалийн юм үзэгдлийн хувьсан өөрчлөгдөх дотоод мөн чанарыг шалтгаан, үрийн холбоогоор нөхцөлдүүлэн тайлбарласнаар чигч шударга

ёсыг уур хилэн эвдэнэ хэмээн илэрхийлсэн ажээ. Мөн хэдэр хэрцгий омог бардмаас зайлсхийх, эелдэг хүнлэг, ажилч хичээнгүй байхыг, олны дунд хэрүүл маргаан үүсгэлгүй биеэ төлөв төвшин, номхон дөлгөөн авч явахыг захин зөвлөж, сургамжилсан байна. Басхүү “Найман түмэн ишваан ишийг цуглуулагч аав ээж минь” хэмээх нь хүн олондоо хүндтэй сайн явж чадах юм бол олон түмнээрээ хүрээлүүлсэн сайн иргэн болно гэсэн нэгэн санааг мөн өгүүлж өгчээ.

*Зүүсн бурхн зүркндө,
Зүүтаа нутук Алтаада,
Махагаала маннаада (магнайдаа),
Манаа нутук Алтаада.
Көрөк (хөрөг) бурхн күзүүндө,
Күмнаа нутук Алтаада,
Очир-Ваани ораандо,*

Ончитаа нутук Алтаада [№ 21. Найман тивтэй Сүмбэр нь, 10-р тал]

Энэхүү дуунд Ойрадуудын Алтай нутгаа магтан дуулдаг, шүтэн биширдэг зан үйл нь илт харагдаж байна. Мөн хойч үе, үр хүүхдүүддээ Алтай нутгаа хайрлан хамгаалж явах хэрэгтэй, Алтай нутагтаа залбирч, шүтэн мөргөж явахад ажил үйлс, санасан хэрэг нь сэтгэлчлэн бүтэх сайны ерөөлтэй байдаг гэх сургамжийг илэрхийлсэн.

*Күнаа газр күчиртаа билаа-л,
Күм болгн зантаа билаа-л,
Алак толгаа тойрн хоюу (хоё),
Амтн болгн зантаа хоюу.
Көндаа болгн кийтн хоюу,*

Көкишит болгн зантаа хоюу [№ 32. Өндөр дээрээ гарью байю, 16-р тал]

Энэхүү дуу нь “Хүний газар хүчтэй, хүчгэний нүхэн бүдрээстэй” буюу “Олон хүн сайнтай муутай, ой мод урттай богинотой”, “Хүний сайныг ханилан байж мэднэ, хүлгийн сайныг унан байж мэднэ” гэх зүйр үгстэй утга ойролцоо ба хүний газар нэрээ бодож зөв явах хэрэгтэй, хүн болгон өөр өөр зан араншинтай хүний эвийг олоод харьцдаг байгаарай хэмээсэн сургамжит дуу болно.

ДҮГНЭЛТ

Ардын дууг тэмдэглэхдээ үгийг уншиж, утгыг ухан ойлгоход дөхөмчлөх зорилгоор үүний үндсэнд ойрад аялгуугаар хэлж ярьж байгааг нэлээд ойролцоо байдлаар тэмдэглэх үүднээс орос үсгийг голлон зарим гаар латин үсэг мэр сэр оруулан галиглах маягаар бичиж боловсруулсан байна. Тод үсгийн тэмдэглэгээнд хэлний урт эгшгийг $\bar{a}/\bar{a}$, $\bar{u}$ үсгээр тэмдэглээд $\bar{a}$, $\bar{e}$, $\bar{o}$, $\bar{u}$, $\bar{o}$, $\bar{u}$ эгшиг хэмээн үздэг тэр мэт онцлогийг сайтар анхааран тэмдэглэсэн нь судлаачийн хувьд халимаг хэл эхэлж үзсэн байдал тун сүрхий нөлөөлсөн бололтой. Үүний тод жишээ нь хэлний урт эгшгийг дандаа $\bar{a}/\bar{a}$ -аар галигласан хийгээд эр эм үгэнд эгшиггүй гийгүүлэгчүүд дараалан тавьж тэмдэглэсэн байна.

Б. Я. Владимирцов баруун монголын нутгаар аялан явж, дөрвөд, баяд, мянгад, захчин ардын дундаас тэмдэглэсэн 118 дуунд ойрад аман аялгууны авиа зүй, үг зүй, үгийн сангийн онцлогийг сайтар тусгасан тул нэгэн зуун жил илүү настай эл бичвэрийн ач холбогдол оршсоор байна, хойшид ч оршсоор байх болно.

Ойрад аялгуунд эм үгийн “к” авиа, дуугүй гийгүүлэгчийн өмнөх гийгүүлэгч дуугүйшсэн, үгийн эцсийн тогтворгүй “н”, үгийн эцсийн тогтвортой “н”-ийг орхиж хэлдгийг, орчин цагийн утга зохиолын хэлний хос эгшгийг урт эгшгээр өгүүлдэг зэрэг авианы хувьсал өөрчлөлтийг тун нарийн тэмдэглэсэн байгаа нь ойрад хэл аялгуу судалгааны чухал эх хэрэглэгдэхүүн юм.

Н о м з ү й

Арван гурван хүлгийн дуун (1984). Эмхтгэж удиртгал тайлбар бичсэн Ж. Цолоо. Ред. Х. Сампилдэндэв. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар.

Владимирцов, Б. Я. (1921). *Монгольский сборник рассказов из Pañcatantra*. Сборник Музея антропологии и этнографии при АН СССР. Петроград: Акад. 12-я гос. тип. 5. 2.

Владимирцов, Б. Я. (1923а). *Монголо-ойратский героический эпос*. Пер., вступ. ст. и примеч. Б. Я. Владимирцова. Петроград–Москва: Гос. изд-во.

Владимирцов, Б. Я. (1923б). *Волшебный мертвец: Сказки* / Пер., вступ. статья и примеч. Б. Я. Владимирцова. Петербург–Москва: Гос. изд-во.

Владимирцов, Б. Я. (1926). *Образцы монгольской народной словесности (С.-З. Монголия)*. Ленинград: Ин-т живых вост. яз. им. А. С. Енукидзе.

Владимирцов, Б. Я. (1929). *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика*. Ленинград: Издание Ленинградского восточного института.

Владимирцов, Б. Я. (1934). *Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм*. Л.: Изд-во АН СССР.

Владимирцов, Б. Я. (2005). *Работы по монгольскому языкознанию*. Москва: Вост. лит.

Омакаева, Э. У. (2014). Из истории изучения письменной традиции ойратов Монголии/ калмыков и образцы письменности монголоязычных народов (по материалам экспедиции 2014 г.). *Мир науки*. 4. 36.

Хорлоо, П. (1981). *Монгол ардын дууны яруу найраг*. Улаанбаатар.

References

Arvan gurban hylgijn duun (1984). Emhtgezhd udirgtal tajlbar bichsen Zh. Coloo. Red. H. Sampildendev. Ulaanbaatar: Ulsyn Hevlelijn Gazar (in Mongolian).

Vladimircov, B. Ya. (1921). *Mongol'skij sbornik rasskazov iz Pañcatantra*. Sbornik Muzeya antropologii i etnografii pri AN SSSR. Petrograd: Akad. 12-ya gos. tip. 5. 2 (in Russian).

Vladimircov, B. Ya. (1923a). *Mongolo-ojratskij geroicheskij epos*. Per., vstup. st. i primech. B. Ya. Vladimircova. Petrograd–Moskva: Gos. izd-vo (in Russian).

Vladimircov, B. Ya. (1923b). *Volshebnyj mertvec: Skazki* / Per., vstup. stat'ya i primech. B. Ya. Vladimircova. Peterburg–Moskva: Gos. izd-vo (in Russian).

Vladimircov, B. Ya. (1926). *Obrazcy mongol'skoj narodnoj slovesnosti (S.-Z. Mongoliya)*. Leningrad: In-t zhivyyh vost. yaz. im. A. S. Enukidze (in Russian).

Vladimircov, B. Ya. (1929). *Sravnitel'naya grammatika mongol'skogo pis'mennogo yazyka i halhaskogo narechiya. Vvedenie i fonetika*. Leningrad: Izdanie Leningradskogo vostochnogo instituta (in Russian).

Vladimircov, B. Ya. (1934). *Obshchestvennyj stroj mongolov*. Mongol'skij kochevoj feodalizm. L.: Izd-vo AN SSSR (in Russian).

Vladimircov, B. Ya. (2005). *Raboty po mongol'skomu yazykoznaniyu*. Moskva: Vost. lit.

Omakaeva, E. U. (2014). Iz istorii izucheniya pis'mennoj tradicii ojratoj Mongolii/ kalmykov i obrazcy pis'mennosti mongoloyazychnyh narodov (po materialam ekspedicii 2014 g.). *Mir nauki*. 4. 36 (in Russian).

Horloo, P. (1981). *Mongol ardyn duuny yaruu najrag*. Ulaanbaatar (in Mongolian).